



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/20

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизээс жил бүр “Цагаан сарын баяр”-т зориулж уламжлал болгон зохион байгуулдаг “Монгол түмний мэнд” нэвтрүүлгийн зардалд 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ

